



СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭДИЙН  
ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

**ИНФОГРАФИК**  
2022 I-VII



Тулгар төрийн 2231  
Их Монгол Улсын 816  
Үндэсний эрх чөлөө, тусгаар  
тогтнолоо сэргээн мандуулсаны 111,  
Ардын Хувьсгалын 100, 101 жил



**ХҮН АМ**

2022 оны эхний 7 сард Сүхбаатар дүүрэгт **1288** хүүхэд шинээр мэндэлж, 1000 хүнд ногдох төрөлт **8.9** болж, өмнөх оны мөн үеийнхээс **1.1** нэгжээр буурчээ.

**1000 ХҮНД НОГДОХ**



▶ Төрөлт **8.9**

Нас баралт **3.2** ◀

**Ердийн цэвэр өсөлт 5.7**

Оны эхний 7 сарын байдлаар нас баралт **469** бүртгэгдэж, 2021 оны мөн үеэс **34-өөр (6.8%)** буурсан бол өмнөх сараас **69-өөр (17.3%)** нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

**ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ**, сүүлийн 5 жилийн эхний 7 сард

**5.7**

**Хамгийн бага**

**Хамгийн их**

**10.3**

*Ердийн цэвэр өсөлт: Хүн амын тооны өсөлт, бууралтыг харуулна.*



**ТӨРСӨН ХҮҮХЭД**

**2021**  
**I-VII**



**1454**

**2022**  
**I-VII**

**1288** ↓

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 7 сард **1276** эх амаржиж, **1288** хүүхэд шинээр мэндэлж, **9-н** амьгүй төрөлт бүртгэгдсэн байна.

Эх, хүүхдийн эндэгдлийн **16** тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **1** тохиолдлоор (**6.6%**) нэмэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.

**ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ**

**11** ↓ 0-1 хүртэлх насны

1-5 хүртэлх насны **5** ↑

- Эхийн эндэгдэл

**ЭХИЙН ТӨРӨЛТ**

**5** ↑ Гэрийн төрөлт

Хяналтгүй төрөлт **4** ↓

Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо **11.8** хувиар буурчээ. Гэрийн төрөлтийн **5**, хяналтгүй төрөлтийн мөн **4** тохиолдол бүртгэгдсэн байна.



## ЭРҮҮЛ МЭНД

### НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

<b>2021 I-VII</b>	Халдварт өвчин	<b>168</b>	
	Цочмог халдварт өвчин	<b>11084</b>	11252
<b>2022 I-VII</b>	Халдварт өвчин	<b>168</b>	12749
	Цочмог халдварт өвчин	<b>12581</b>	

2022 оны эхний 7 сард 10.0 мянган хүн тутмын 870 нь цочмог, 12 нь халдварт өвчнөөр өвчилсэн байна.

### ХАЛДВАРТ ӨВЧИН - 168



### ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН - 12581



Коронавирус халдварын тохиолдол оны эхний 1 сард 8765, 2 сард 2641, 3 сард 651 бүртгэгдэж, харин 4 болон 5 сард бүртгэгдээгүй эерэг үзүүлэлттэй байсан бол 6 сард 360 тохиолдол бүртгэгдсэн сөрөг үзүүлэлттэй, мөн 7 сард бүртгэгдээгүй байна.



## НИЙГМИЙН ХАЛАМЖ



### Ehalamj системээр 2022 оны 7 сард олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийн мэдээ

	2022 I	2022 VII
Халамжийн тэтгэвэр	1 815 хүн 522.2 сая төг	1 941 хүн 546.5 сая төг
Алдарт эх одонгийн мөнгө	7 939 хүн 971 сая төг	40 хүн 4.1 сая төг
Алдар цолтон ахмад настан хөнгөлөлт	5 хүн 1.2 сая төг	4 хүн 1.0 сая төг
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	51 525 хүн 5 152.5 сая төг	52 358 хүн 5 235.8 сая төг
Бусад тэтгэмж	17 516 хүн 1 340.9 сая төг	10 372 хүн 826.3 сая төг



## НИЙГМИЙН ДААТГАЛ

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

	2021 I-VII	2022 I-VII
ОРЛОГО, тэрбум төгрөг	159.8*	224.0 ↑
ЗАРЛАГА, тэрбум төгрөг	84.4	102.4 ↑
ОЛГОСОН ТЭТГЭВЭР		
Тэтгэвэр авагчийн тоо, мянган хүн	20.2	21.1 ↑
Олгосон тэтгэвэр, тэрбум төгрөг	67.2	86.2 ↑
ОЛГОСОН ТЭТГЭМЖ		
Хамрагдсан хүн, мянган хүн	15.8	19.4 ↑
Олгосон тэтгэмж, тэрбум төгрөг	17.2	16.2 ↓




## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

2021 I-VII 555 2022 I-VII 461↓



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2022 I-VII




Дүүргийн ХХҮХ-т бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 7 сарын эцэст 461 болж, өмнөх оны мөн үеэс 94-өөр (16.9%) буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдээс 7 сард 250 иргэн ажилд зуучлагдан орсон нь өмнөх сараас 122-оор (32.8%) буурчээ.



## БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

2021 I-VII



1110

2022 I-VII



2129↑

1-р хэлтэс

2-р хэлтэс

(1-9 дүгээр хороо)

(10-20 дугаар хороо)

Бүртгэгдсэн гэмт хэрэг 1408 (66.1%)

Бүртгэгдсэн гэмт хэрэг 721 (33.9%)

Илрүүлэлт 35.2%

Илрүүлэлт 44.8%

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 7 сард 1-р хэлтэст 1408, 2-р хэлтэст 721, нийт 2129 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс 1019 хэргээр 1.9 дахин өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн илрүүлэлт дүүргийн хэмжээнд 38.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.8 нэгж хувиар нэмэгджээ.

Мөн зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 9217 бүртгэгдсэн байна.



## БҮРТГЭГДСЭН ТҮЙМЭР, ҮЕР, УС

БҮРТГЭГДСЭН ГАЛ ТҮЙМЭР, төрлөөр

2021 I-VII

2022 I-VII



67

98↑

Объектын



5

21↑

Хогны



5

65↑

Өнжмөл шар өвсний

БҮРТГЭГДСЭН ҮЕР, УСНЫ ДУУДЛАГА



16

1↓

Үер ус, халиа дошин

2022 оны эхний 7 сард дүүргийн хэмжээнд объектын гал түймрийн 98, хогны 21, өнжмөл шар өвс шатсан 65, халиа дошны 1, нийт 185 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 92-оор буюу 2.0 дахин нэмэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн гал түймрийн өсөлтөд өнжмөл шар өвс шатсан дуудлага 60-аар буюу 13.0 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, сая төгрөг



Төлөвлөгөө 173 444.6

Гүйцэтгэл 146 643.5

Биелэлт 84.5%

2022 оны эхний 7 сард дүүргийн төсөвт 146.6 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 84.5 хувиар биелжээ. Төвлөрсөн орлогын 95.7 хувийг урсгал орлого, 4.3 хувийг төсвийн урсгал санхүүжилтийн орлого эзэлж байна.

Харин урсгал орлогын 99.2 хувийг татварын орлого, 0.8 хувийг татварын бус орлого бүрдүүлжээ.

ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА, сая төгрөг



Төлөвлөгөө 171 044.5

Гүйцэтгэл 144 850.7

Биелэлт 84.7%


Оны эхний 7 сарын байдлаар төвлөрсөн орлогын 98.8% буюу 144.9 тэрбум төгрөгийг урсгал зардалд зарцуулаад байна.

Урсгал зардлын дийлэнх буюу 99.7%-ийг бараа үйлчилгээний, 0.3%-ийг бусад зардал эзэлж байна.



## АЖ ҮЙЛДВЭР (\*урьдчилсан гүйцэтгэл)

2021 Нийт үйлдвэрлэл 2 114.7 тэрбум  
I-VII Нийт борлуулалт 4 172.5 төгрөг



2022 Нийт үйлдвэрлэл 1 892.7\*↓ тэрбум  
I-VII Нийт борлуулалт 3 598.7\*↓ төгрөг

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

2021 I-VII

2022 I-VII

УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ (7.4%↑)

1 651.1  
тэрбум төгрөг



1 773.3\*↑  
тэрбум төгрөг

БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (74.3%↓)


461.3  
тэрбум төгрөг



118.5\*↓  
тэрбум төгрөг

ЦАХИЛГААН, ДУЛААН, ЭРЧИМ ХҮЧ, УСАН  
ХАНГАМЖ ҮЙЛДВЭРЛЭЛ (60.9%↓)

2.3  
тэрбум төгрөг



0.9\*↓  
тэрбум төгрөг



## ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ



Цэвэрлэсэн зам  
талбай 436.8 мян.м2  
Зарцуулсан хөрөнгө  
1 749.8 сая төгрөг

ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ, байршлаар, 2022 I-VII

21 638.0  
ТН

Орон сууцнаас



Гэр хорооллоос

12 789.0  
ТН

7 820.3  
ТН

Зуслангаас



2022 оны эхний 7 сард дүүргийн хэмжээнд 42.2 мянган тонн хог тээвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 9.0 мянган тонноор буюу 27.1 хувиар өсжээ.

Тээвэрлэсэн хогны 51.2 хувийг орон сууцнаас, 30.3 хувийг гэр хорооллоос, 18.5 хувийг зуслангаас тус тус тээвэрлэжээ.

Хог тээвэрлэлтэд нийт 1749.8 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 521.9 сая төгрөгөөр (42.5%) өссөн үзүүлэлттэй байна.

